



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/51/СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2021 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Аудитын менежер: Утас: 7058-4207 Аудитор: Утас: 7000-3775	Цахим хаяг: <a href="mailto:bolortuulb@audit.gov.mn">bolortuulb@audit.gov.mn</a> И.Сэмжидмаа Цахим хаяг: <a href="mailto:semjidmaai@audit.gov.mn">semjidmaai@audit.gov.mn</a> Э.Нандинчимэг Цахим хаяг: <a href="mailto:khaanconsultingaudit@gmail.com">khaanconsultingaudit@gmail.com</a>
--	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд

## Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
<b>3.9. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>13</b>
<b>Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....</b>	<b>14</b>
<b>3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....</b>	<b>15</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 288

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН  
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст хөрөнгийн тооллогыг хийж дуусаагүй, үр дүнг тооцоогүй санхүүгийн тайлан баланс илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2 дахь "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба

011020255



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,081,045.68</b>	<b>36,115,641.35</b>
33	АВЛАГА	-	89,000.00
335	Бусад авлага	-	89,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	89,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>24,081,045.68</b>	<b>36,026,641.35</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,356,581.68</b>	<b>15,069,467.35</b>
35110	Тусгай зориулалттай материал	478,318.00	478,318.00
35130	Эм боох материал	1,878,263.68	14,591,149.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>21,213,464.00</b>	<b>20,858,174.00</b>
35410	Бичиг хэргийн материал	763,980.00	741,900.00
35420	Аж ахуйн материал	837,000.00	812,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,329,360.00	443,250.00
35460	Хүнсний материал	337,100.00	-
35470	Бусад хангамжийн материал	17,946,024.00	18,861,024.00
35500	Биологийн хөрөнгө	511,000.00	99,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>356,585,320.89</b>	<b>364,183,068.61</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>356,585,320.89</b>	<b>364,183,068.61</b>
<b>392</b>	<b>Биег хөрөнгө</b>	<b>320,585,320.89</b>	<b>328,183,068.61</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	256,203,666.63	256,203,666.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,543,636.96)	(8,268,486.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,506,834.00	33,506,834.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(12,443,526.63)	(17,399,598.99)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	70,637,076.00	97,035,876.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,163,752.48)	(36,389,924.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,151,850.00	16,151,850.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,814,858.55)	(12,657,148.40)
39209	Зам, гүүрийн байгууламж	4,428,400.00	4,428,400.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(4,376,731.12)	(4,428,400.00)
<b>393</b>	<b>Биег бус хөрөнгө</b>	<b>36,000,000.00</b>	<b>36,000,000.00</b>
39303	Бусад биег бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>380,666,366.57</b>	<b>400,298,709.96</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>2,380,733.21</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГААЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>2,380,733.21</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>-</b>	<b>2,380,733.21</b>
41310	Ажилчилтай холбогдсон өглөг	-	2,325,373.21
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	55,360.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>380,666,366.57</b>	<b>397,917,976.75</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>380,666,366.57</b>	<b>397,917,976.75</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	294,572,263.12	294,572,263.12
51101	Өмч - төрийн	258,572,263.12	258,572,263.12
51103	- хувьцаат	36,000,000.00	36,000,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(16,753,239.76)</b>	<b>498,370.42</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(16,753,239.76)	(16,753,239.76)
51220	Тайлант үеийн үр дүн	-	17,251,610.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	102,847,343.21	102,847,343.21
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-IV+V</b>	<b>380,666,366.57</b>	<b>400,298,709.96</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>332,060,733.22</b>	<b>358,886,308.65</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>321,812,533.22</b>	<b>337,153,537.15</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,092,233.22	35,397,237.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,092,233.22	35,397,237.15
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,092,233.22	35,397,237.15
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	304,720,300.00	301,756,300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	293,239,400.00	289,777,600.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	11,480,900.00	11,978,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,248,200.00</b>	<b>21,732,771.50</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,225,400.00	12,934,081.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,225,400.00	12,934,081.50
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	9,022,800.00	8,798,690.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,022,800.00	8,798,690.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>322,031,941.38</b>	<b>341,634,698.47</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>322,031,941.38</b>	<b>341,634,698.47</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	306,036,384.25	341,587,028.74
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	189,237,209.63	213,689,750.48
210101	Үндсэн цалин	182,991,573.63	140,526,842.48
210102	Нэмэгдэл	3,015,717.00	53,357,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,090,104.00
210104	Урамшуулал	3,229,919.00	15,715,667.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,801,170.97	26,832,614.06
210201	Тэтгэврийн даатгал	15,305,877.89	18,585,082.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,460,270.53	2,080,379.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,360,795.80	1,700,901.72
210204	Ажилгүйдлийн даатгал	334,021.60	372,752.01
210205	Эрүүл мэндийн даатгал	3,340,205.15	4,093,498.45
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,420,010.93	10,980,459.86
210301	Гэрэл, цахилгаан	2,059,784.00	1,901,426.86
210302	Түлш, халаалт	8,090,226.93	8,629,033.00
210303	Цэвэр, бохир ус	270,000.00	450,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,587,640.00	17,528,350.00
210401	Бичиг хэрэг	1,443,270.00	2,161,080.00
210402	Тээвэр, шатахуун	11,369,340.00	11,814,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	923,300.00	800,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,008,700.00	1,616,500.00
210406	Бага үнэтэй, гүргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	843,030.00	1,136,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	27,691,382.74	30,114,527.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,718,902.74	19,839,827.99
210502	Хоол, хунс	6,774,980.00	8,146,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,197,500.00	2,128,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,553,900.00	3,618,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,152,500.00
210604	Урсгал засвар	8,553,900.00	1,465,600.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	2,481,900.00	2,132,800.00
210702	Дотоод албан томилголт	2,481,900.00	2,132,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,274,190.29	16,786,374.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,677,350.29	16,366,374.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	87,840.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	240,000.00	240,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,988,979.69	19,904,052.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,385,000.00	1,103,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорөгдол	11,603,979.69	18,801,052.28
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,995,557.13	47,669.73
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15,995,557.13	47,669.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,995,557.13	47,669.73
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>10,028,791.84</b>	<b>17,251,610.18</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,028,791.84</b>	<b>17,251,610.18</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>314,968,500.00</b>	<b>323,489,071.50</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>304,720,300.00</b>	<b>301,756,300.00</b>
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>304,720,300.00</b>	<b>301,756,300.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	293,239,400.00	289,777,600.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	11,480,900.00	11,978,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>10,248,200.00</b>	<b>21,732,771.50</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,225,400.00</b>	<b>12,934,081.50</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,225,400.00	12,934,081.50
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>9,022,800.00</b>	<b>8,798,690.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,022,800.00	8,798,690.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>314,968,500.00</b>	<b>323,489,071.50</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>314,968,500.00</b>	<b>323,489,071.50</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>298,972,942.87</b>	<b>323,441,401.77</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>178,570,279.63</b>	<b>211,884,031.95</b>
210101	Үндсэн цалин	151,884,925.63	138,721,123.95
210102	Нэмэгдэл	16,873,592.00	53,357,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,090,104.00
210104	Урамшуулал	9,811,762.00	15,715,667.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,755,418.90</b>	<b>26,312,959.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	15,397,334.40	18,065,427.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,533.36	2,080,379.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,545,337.95	1,700,901.72
210204	Ажилгүйдлийн даатгал	349,928.53	372,752.01
210205	Эрүүл мэндийн даатгал	3,499,284.66	4,093,498.45
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,480,210.93</b>	<b>10,513,099.86</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,059,784.00	1,901,426.86
210302	Тулш, халаалт	9,060,426.93	8,161,673.00
210303	Цэвэр, бохир ус	360,000.00	450,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,444,200.00</b>	<b>17,120,060.00</b>
210401	Бичиг хэрэг	1,922,320.00	2,139,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,764,400.00	10,928,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	923,300.00	800,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,617,100.00	1,616,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,217,080.00	1,636,400.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>22,905,546.05</b>	<b>29,692,586.51</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,814,996.05	19,754,986.51
210502	Хоол, хүнс	7,033,550.00	7,809,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,057,000.00	2,128,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,956,765.00</b>	<b>6,762,590.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,902,865.00	5,296,990.00
210602	Тавилга	1,500,000.00	-
210604	Урсгал засвар	8,553,900.00	1,465,600.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>2,481,900.00</b>	<b>2,132,800.00</b>
210702	Дотоод албан томиллолт	2,481,900.00	2,132,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,013,622.36</b>	<b>16,786,374.08</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,390,032.36	16,366,374.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	210,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	87,840.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,750.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	240,000.00	240,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,365,000.00</b>	<b>2,236,900.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,365,000.00	2,236,900.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,995,557.13</b>	<b>47,669.73</b>
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>15,995,557.13</b>	<b>47,669.73</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,995,557.13	47,669.73
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	294,572,263.12	102,847,343.21	-16,753,239.76	0.00	380,666,366.57
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>294,572,263.12</b>	<b>102,847,343.21</b>	<b>-16,753,239.76</b>	<b>0.00</b>	<b>380,666,366.57</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>294,572,263.12</b>	<b>102,847,343.21</b>	<b>-16,753,239.76</b>	<b>0.00</b>	<b>380,666,366.57</b>
<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>294,572,263.12</b>	<b>102,847,343.21</b>	<b>-16,753,239.76</b>	<b>0.00</b>	<b>380,666,366.57</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>294,572,263.12</b>	<b>102,847,343.21</b>	<b>-16,753,239.76</b>	<b>0.00</b>	<b>380,666,366.57</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	17,251,610.18	0.00	17,251,610.18
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>294,572,263.12</b>	<b>102,847,343.21</b>	<b>498,370.42</b>	<b>0.00</b>	<b>397,917,976.75</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	324,610,100.00	297,038,741.83	324,488,400.00	310,507,320.27
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	324,610,100.00	297,038,741.83	324,488,400.00	310,507,320.27
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	324,610,100.00	297,038,741.83	324,488,400.00	310,507,320.27
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	202,058,800.00	178,570,279.63	213,619,300.00	211,884,031.95
210101	Үндсэн цалин	160,539,300.00	151,884,925.63	143,398,400.00	138,721,123.95
210102	Нэмэгдэл	22,193,200.00	16,873,592.00	51,540,100.00	53,357,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	4,536,000.00	4,090,104.00
210104	Урамшуулал	19,326,300.00	9,811,762.00	14,144,800.00	15,715,667.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,257,400.00	22,755,617.86	26,624,400.00	26,312,959.37
210201	Тэтгэврийн даатгал	17,174,500.00	15,397,533.36	18,157,700.00	18,065,427.73
210202	Тэтгэмжийн даатгал	2,020,500.00	1,963,533.36	2,116,700.00	2,080,379.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,616,400.00	1,545,337.95	1,693,300.00	1,700,901.72
210204	Ажилгүйдлийн даатгал	404,400.00	349,928.53	423,300.00	372,752.01
210205	Эрүүл мэндийн даатгал	4,041,600.00	3,499,284.66	4,233,400.00	4,093,498.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	11,480,900.00	11,480,210.93	10,750,000.00	10,513,099.86
210301	Гэрэл, цахилгаан	2,075,000.00	2,059,784.00	2,000,000.00	1,901,426.86
210302	Түлш, халаалт	9,045,400.00	9,060,426.93	8,300,000.00	8,161,673.00
210303	Цэвэр, бохир ус	360,500.00	360,000.00	450,000.00	450,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,438,600.00	16,398,800.00	17,436,500.00	16,909,960.00
210401	Бичиг хэрэг	1,950,000.00	1,922,320.00	2,500,000.00	2,139,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,719,400.00	10,719,000.00	10,719,400.00	10,717,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	934,000.00	923,300.00	900,000.00	800,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,617,100.00	1,617,100.00	1,617,100.00	1,616,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,218,100.00	1,217,080.00	1,700,000.00	1,636,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	22,526,400.00	22,525,546.05	19,475,500.00	17,724,605.01
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,538,200.00	14,434,996.05	10,170,700.00	9,070,005.01
210502	Хоол, хүнс	7,034,400.00	7,033,550.00	7,034,400.00	6,526,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	953,800.00	1,057,000.00	2,270,400.00	2,128,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,959,000.00	16,956,765.00	8,100,000.00	6,762,590.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,903,000.00	6,902,865.00	5,900,000.00	5,296,990.00
210604	Урсгал засвар	8,556,000.00	8,553,900.00	2,200,000.00	1,465,600.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	2,883,100.00	1,771,900.00	2,000,000.00	1,376,800.00
210702	Дотоод албан томилот	2,883,100.00	1,771,900.00	2,000,000.00	1,376,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,439,900.00	21,013,622.36	23,667,000.00	16,786,374.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	20,660,000.00	20,390,032.36	22,968,100.00	16,366,374.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	268,000.00	210,000.00	180,000.00	180,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	245,000.00	240,000.00	245,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,566,000.00	5,566,000.00	2,815,700.00	2,236,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,566,000.00	5,566,000.00	2,815,700.00	2,236,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	324,610,100.00	297,038,741.83	333,286,990.00	310,554,990.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	324,610,100.00	297,038,741.83	324,488,400.00	301,756,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	324,610,100.00	297,038,741.83	324,488,400.00	301,756,300.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	8,798,590.00	8,798,690.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	-	8,798,590.00	8,798,690.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>12,934,081.50</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>12,934,081.50</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	12,934,081.50
2104	Хангамж, бараа материалын зардал	-	210,100.00
210402	Тээвэр, шатахуун	-	210,100.00
2105	Нормативт зардал	-	11,967,981.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	10,684,981.50
210502	Хоол, хүнс	-	1,283,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	756,000.00
210702	Дотоод албан томилголт	-	756,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>12,934,081.50</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>12,934,081.50</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	12,934,081.50
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Золжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

2020 онд нийт 8 бүлэг 46 зүйлийн үйл ажиллагаа төлөвлөн ажилласан. Хагас жилийн байдлаар цар тахалтай холбоотой зарим үйл ажиллагаа хийгдэх боломжгүй болсон.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 341,635.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 6,833.0 мянган төгрөгөөр тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сэргэлэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,632.3 мянган төгрөгөөр буюу 1.05 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	89.0	89.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	24,081.04	36,026.6	11,945.6
Үндсэн хөрөнгө	416,927.83	443,326.63	26,398.80
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(60,342.51)	(79,143.56)	(18,801.05)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>380,666.3</b>	<b>400,298.7</b>	<b>19,632.3</b>
Өр төлбөр	-	2,380.7	2,380.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	294,572.2	294,572.2	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>380,666.3</b>	<b>400,298.7</b>	<b>19,632.3</b>

Авлага дансны үлдэгдэлд байгууллагаас авах 89.0 үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,026.6 мянган төгрөг болж 11,945.6 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн бараа материалын худалдан авалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 443,326.63 мянган төгрөг болж 26,398.8 мянган төгрөгөөр өссөн нь 24,800.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хандиваар авсан болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1598.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд ажилчидтай холбоотой өглөг 2,380.7 мянган төгрөгийн үлдэгдэл байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Сэргэлэн Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 26,825.5 мянган төгрөгөөр буюу 8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 19,603.0 мянган төгрөгөөр буюу 6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагдсан зэргээс шалтгаалсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 333,286.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 333,286.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 301,756.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 301,756.3 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 289,777.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 11,978.7 мянган төгрөг, эрүүл мэнд нийгмийн даатгалын сангаас 8,798.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 310,554.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 310,507.3 төгрөгийг зарцуулж, 47.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 310,507.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 238,196.9 мянган төгрөг буюу нийт зардлын 75.7 хувийг эзэлж байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт үйл ажиллагаанаас 12,934.1 мянган төгрөгийн орлого орсон байна. Нэмэлт үйл ажиллагааны зардлаас 210.1 мянган төгрөгийг тээвэр шатахуун, 10,685.0 мянган төгрөгийг эм, бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл, 1,283.0 мянган төгрөгийг хоол, хүнс, 756.0 мянган төгрөгийг томилолтын зардалд зарцуулсан байна.

## **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 139 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 122 мэдээлэл, хугацаа хоцорч 17 мэдээлэл оруулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн 320,739.1 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

## **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитын зөвлөмжийг биелүүлж ажилласан, 1 төлбөрийн актыг барагдуулж биелэлтийг хугацаандаа хүргүүлсэн байна.

## **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 517,143.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 517,143.1 мянган төгрөгийн зөрчилд 667.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 516,475.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 517,143.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 517,143.1 мянган төгрөгийн зөрчилд 667.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 516,475.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХСайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 667.3 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтын хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Худалдан авалтын 4,463.1 мянган төгрөгт гэрээ хийгээгүй, төлбөрийн үлдэгдэлд тулган баталгаажуулалт хийгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст 2,469.3 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгасан боловч тулган баталгаажуулах анхан шатны баримт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант оны эцэст 473,353.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

5. Шатахууны зардалд 2,722.5 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас байхгүй анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй зардал гаргасан нь нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

6. Тайлант хугацаанд гарсан зардлаас 33,467.7 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан

“Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгаа, эргэлтийн эмийн сангийн тооцоо болон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй учир дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.05</b>	Аудитын нэр: <b>Дорнод аймгийн Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ДОА-2021/51/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Дорнод аймгийн Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төв</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийгээгүй байна. Үндсэн хөрөнгө – 443,326.6 мянган төгрөг, БМ- 36,026.6 мянган төгрөг байна.	473,353.2	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг
2	Нийт 122 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 17 мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна. Үүнд: 1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр) - мэдээлэл оруулаагүй 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр) 6 болон 12 сард 3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 12 сард мөнгөн дүн 320,739.1 мянган төгрөг 4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) 5. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр) 6. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Бүтэн жилээр) -мэдээлэл оруулаагүй 7. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл (Бүтэн жилээр, Сар бүр) 8. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 12 сард 9. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,	0.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг

	9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) 12 сард 11. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 12. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан (Бүтэн жилээр) 13. Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) 14. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт (Сар бүр) 15. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)				
3	Тайлант хугацаанд 4,463.1 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан бөгөөд Нүүрс нийлүүлэх гэрээ байхгүй, мөнгө шилжүүлсэн баримтад төрийн сангаар баталгаажуулж тамга дарсан баримт байхгүй. Тээврийн хөлс олгох гэрээ баримтад байхгүй. Хувь хүнд 359.8 мянган төгрөгийн өглөг үүссэн балансад тусгаагүй. Найнги нүүрсний уурхайд 55.3 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлж баталгаажуулсан акт байхгүй.	4,463.1	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг
4	Жилийн эцэст Санхүүгийн тайланд өглөг 2,380.7 мянган төгрөг, 89.0 мянган төгрөгийн авлага тусгагдсан ч түүнийг баталгаажуулсан тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна.	2,469.3	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг
5	Цахим төлбөрийн системд 33,467.7 мянган төгрөгийн и-баримт илгээгдээгүй байна.	33,467.7	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг
6	Шатахууны зардалд 2,722.5 мянган төгрөгийн жолоочийн тооцооны хуудас байхгүй анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй зардал гаргасан байна.	2,722.5	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг
7	Батлагдсан төсөв 10,719.4 мянган төгрөг ба шатахуун зарцуулалт батлагдсан төсвөөс хэтрээгүй ч жишиг нормоор тооцоолоход 667.3 мянган төгрөгийн илүү зарцуулалттай байна.	667.3	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Б.Золжаргал Г.Мөнхцэцэг
<b>ДҮН</b>		<b>517,143.1</b>			